



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Хурал: 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 15.00 цагт Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Самбуугийн гудамж хаягт байрлах Улаанбаатар зочид буудлын “Сонгинохайрхан танхим”-д болсон.

Хурлын дарга: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 07 дугаартай тогтоолоор хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Пүрэвсүх овогтой Нямдоржийг томилсон.

Хурлын ирц: Ирц бүртгэл, санал хураалтыг Си Эм Си Консалтинг ХХК-ийн боловсруулсан hural.basaltwool.mn цахим хуудас ашиглан явуулсан болно. Хурлын ирцийн дэлгэрэнгүй жагсаалтыг тэмдэглэлд хавсаргана. Хуралд нийт 39,561,305 ширхэг хувьцаа эзэмшиж буй саналын эрхтэй 69 хувьцаа эзэмшигч өөрөө биечлэн, эцэг эх хувьд болон итгэмжлэлийн дагуу оролцсон байна.

Хэлэлцэх асуудал: Монгол базальт ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Хурлын дарга П.Нямдорж: Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та бүхэндээ баярлалаа. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдээс гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ш.Энхтөр, Ч.Зоригтбаатар, ердийн гишүүн Б.Шаравсамбуу, Г.Ганзориг нар, Хөндлөнгийн аудит хийж дүгнэлт гаргасан “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК-ийн аудитор Бат-Оргил нар хүрэлцэн ирсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 07 дугаартай тогтоолоор томилогдсон Тооллогын комиссын даргаар Т.Ууганцэцэг, гишүүдээр Б.Амаржаргал, Э.Цэрэнпагма нарыг томилсон байна. Тооллогын комиссын дарга ирц болон тогтоолыг танилцуулна.

Т.Ууганцэцэг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2025.04.30-ны өдрийн 01 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай тогтоолыг танилцуулья.

Тогтоолд: “Монгол базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 56,417,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 2521 хувьцаа эзэмшигчдээс 69 хувьцаа эзэмшигчийн 39,561,305 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 70.12% болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хурлын дарга П.Нямдорж: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал болон Компанийн 2024 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал

бэлтгэн хэвлүүлж брокер, диллерийн компаниар дамжуулан хүргүүлсэн ба компанийн цахим хуудас байршуулсан байсан. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан хэлэлцэх асуудал, дэгийн дагуу хурлаа үргэлжлүүлье.

Дэгийг уншиж танилцуулав.

Ингээд компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал А.Энхгэрэлийг индэрт урьж байна.

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: Өдрийн мэнд хүргэе. Сайхан хаваржиж байна уу? Өөрийн биеэр компанийхаа хуралд ирж оролцож байгаа та бүхэндээ маш их баярлалаа. Эхний ээлжинд компанийн 2024 оны санхүү, үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг танилцуулна. Түүний дараа бид энэ жилтээ хэрэгжүүлж эхэлсэн төсөл хөтөлбөр болон хамтран ажиллаж байгаа байгууллага, нэгжүүдээ танилцуулна. Юуны түрүүнд хурлын материалд тараасан байгаатай танилцсан байх. 2024 он 2023 онтой харьцуулахад санхүүгийн үзүүлэлтүүд бага зэргийн өсөлттэй гарсан байгаа нь бидний бизнес төлөвлөгөөнд төлөвлөсөн хүлээлтээс 20 орчим хувиар бага байгаа боловч барилгын салбарын зах зээл, валютын ханшийн өөрчлөлт, инфляци, үйлдвэрлэлийн хүчин чадал зэрэг маш олон дотоод болон гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөр 3000 орчим тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлсэн байна. Борлуулалтын орлого маань 12 орчим тэрбум төгрөг давсан үзүүлэлттэй байна, бид байнга борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 50-60 хувьд барих төлөвлөгөөтэй ажилладаг, аль болох зардлын менежмент хийж, ашгийг өндөр байлгахаар ажиллаж ирсэн. 2024 оны зах зээлийн дотоод хүчин зүйлс, нилээд том хэлбэлзлүүд, түлш шатахууны доголдол, цахилгааны үнийн огцом өсөлт зэргээс шалтгаалан ББӨ-ийг 60-аас доош хувь байлгаж чадсангүй. Гэхдээ 2025 ондоо ББӨ-г 60 хувиас илүү гаргахгүй байх боломжтой гэж харж байна, 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар 56 хувьтай байна.

Бид хувьцаа эзэмшигчд, хөрөнгө оруулагч нартаа зориулж үйл ажиллагааны тайланг видео хэлбэрт оруулж нийтэд мэдээлдэг ба энэ уламжлалын дагуу компанийн вебсайтад байрлуулсан байгаа.

ХЭХ-д дэлгэцээр танилцуулах РРТ-г тэмдэглэлд хавсаргасан ба дэлгэцийн харагдах байдал товч:



Өнгөрсөн 2 жилийн хугацаанд бид жилдээ тэрбум гаруй төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2024 онд нилээдгүй олон төсөл хөтөлбөрийг эхлүүлж санхүүжүүлсэн, шинэ үйлдвэр угсарч бүтээгдэхүүний нэр төрлийг нэмгдүүлэх хөрөнгө оруулалтуудыг хийснээр цэвэр ашгийн хэмжээ 130 гаруй сая төгрөг болсон байгаа. Гэхдээ 2025 ондоо бид энийг нөхөж хамгийн багадаа 15-20 хувийн цэвэр ашигтай ажиллахаар бизнес төлөвлөгөө баталуулан хэрэгжүүлж байна. Үүнээс үүдэлтэйгээр 2024 оны 6 сараас хойш хүний нөөцийн чадахид ихээхэн анхаарч барилгын материалын технологийн нарийн мэргэжилтэй, мэргэшсэн туршлагатай инженерүүдийг ажиллуулж байна. Манай үйлдвэр барилгын материалын шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаатай холбогдуулан Монгол улсын стандартуудыг шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах ажлуудыг хийж байна. Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, шинэ болон өнөөдрийг хүртэл тогтвортой ажиллаж байгаа инженерүүд ажилтнуудыгаа авч үлдэх, цаашид бүтээмжийг нэмэгдүүлэх болон ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг бодлогын хүрээнд цалин хөлсийг 20 гаруй хувиар нэмэгдүүлсэн нь үйл ажиллагааны зардал 2 тэрбум гаруй төгрөгийг эзэлж байгаа юм. Нээлттэй ХК болсноос хойш бид ТУЗ-ийн бодлого, компанийн хөгжил дэвшлийн философи, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүнд үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа цорын ганц үндэсний үйлдвэрлэгчийн хувьд тодорхой хэмжээнд бага ч гэсэн цэвэр ашигтай ажиллаж ч байгаа бол тогтмол ногдол ашгийг тараана гэсэн бодлогынхоо хүрээнд 2024 оны цэвэр ашгийг бүрэн буюу нэгж хувьцаанд 2.42 төгрөгийг тараахаар шийдвэрлэсэн, өнөөдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тарааж байгаа.

Өнгөрсөн жил хувьцаа эзэмшигчдийн ерөнхий бүтцэд томоохон өөрчлөлт гараагүй, ХЭХ-ийн бүртгэлийн өдрийн байдлаар 2521 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна. Хувьцааны үнэ ханшны тухайд та бүхэн байнгын мэдээлэлтэй байгаа гэж бодож байна. Компанийн засаглалын кодексын үнэлгээгээр 2023 онд манай компани 86 хувьтай байсан бол 2024 онд 93 хувь болж өөрчлөгдсөн ба засаглал хэвийн, эрсдэлгүй гэсэн үнэлгээтэй байгаа юм. Энэ үнэлгээнд нөлөөлсөн зүйл бол ТУЗ-ийн дэргэд эрсдлийн удирдлагын хороо байгуулж, комплайнсын ажилтантай болсон байгаа. 2024 ондоо бид нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001, 14001, 45001 стандартуудыг нэвтрүүлж, баталгаажуулалт хийгдсэн байгаа, үүний хүрээнд дотоод хяналт, менежмент сайжирсан байгаа.

Үүний зэрэгцээ Байгаль орчин нийгэм засаглалын /ESG/ бодлогыг компанийн стратеги зорилт, бодлого тодорхойлохдоо нэвтрүүлж, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл бага, ээлтэй үйлдвэр болж чадсан байгаа юм. Чулуун хөвөн дулаан тугаарлагч материалыг МУ-даа бий болгож, шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, шинэ норм дүрэм батлуулж мөрдөх болсон 20 жил өнгөрсөн ба хамгийн гол нь эрүүл аюулгүй орчинд амьдрах, галын аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг хийж ирсэний үр дүнд 2024 онд цагт 3 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай болсон байгаа нь дотоодын чулуун хөвөн дулаалгын материалыг дангаар хангах боломжтой болж байгаа юм. Тиймээс цаашид үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагагүй болсон, харин шинэ бүтээгдэхүүн, шинэ орлогын эх үүсвэр бий болгох, эрчим хүчний салбарт яаж ашиглах уу зэрэг зорилтуудыг дэвшүүлэх болсон. Энэ ажлын хүрээнд хийгдсэн төсөл, хөтөлбөр, шинэ бүтээгдэхүүнийг танилцуулах боломжтой болсон.

Өнгөрсөн жилийн ХЭХ дээр бид 4 улирлын гидропоник хүлэмжийн төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа гэж танилцуулж байсан, тэгвэл энэ жил гидропоник хүлэмжийн барилгын ажил 40 хувьтай явагдаж байна, 2025 он дуусахад бид жилдээ 150 тонн ургац хурааж авах боломжтой болж байгаа юм. Энэ ажил нь Атрын дөрөвдүгээр аяны хүрээнд хэрэгжүүлэх зорилт тавьсан, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж явбал жилд 1-2 тэрбум төгрөгийн орлого болж, хамгийн гол нь эрүүл, генийн өөрчлөлтгүй бүтээгдэхүүн болох юм. Энэ төслийг сонгосон шалтгаан нь манай чулуун хөвөн бүтээгдэхүүн нь хөрсний

орлуулагч байдлаар хэрэглэж болдог учир маш сонирхолтой, бидний орох ёстой зах зээлүүдийн нэг нь гэж үзэж байгаа юм. Энэ төслийн хүрээнд Улаанбаатар хотын болон Дархан хотын хөдөө аж ахуйн сургуультай хамтран гидропоник хүлэмж, хөрсгүй тариалалтын судалгаа шинжилгээ, үр судалгааны ажлуудыг хийж байгаа юм.

2025 оны 3 сард Пассив базальт панел хийцийн үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулсан байгаан Энэ бүтээгдэхүүн нь уламжлалт амины орон сууцнаас юугаараа онцлог вэ гэхээр эрчим хүчний өндөр хэмнэлттэй буюу энгийн орон сууцнаас 90 хувийн цахилгаан, дулаан бага хэрэглэдэг. Үйлдвэр бүрэн ашиглалтад орсон тул пассив базальт панель хийц бүтээгдэхүүн танилцуулах нээлттэй өдөрлөгийг 3-4 сард зохион байгуулсан, цаашид ч энэ бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулах ажлууд хийгдэх болно. Улаанбаатар хотын агаарын бохирдол бууруулах чиглэлээр төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран ногоон жишиг хороолол бий болгохоор ажиллах саналууд ирж байгаа. Манай компаниас бүтээгдэхүүнийг ашиглаж шууд байшин барих боломжтой зураг төслийг бэлтгэсэн, энэ нь барилгын компани, гүйцэтгэгч нарт болон хувь иргэдэд зориулсан хоёр төрөл байгаа. Та бүхэн танхимд дэлгэсэн пассив базальт панель хийц бүтээгдэхүүнтэй танилцаж, манай менежрүүдээс дэлгэрэнгүй мэдээлэл аваарай. Мөн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралдаа бичлэн оролцож байгаа хувьцаа эзэмшигчидээ урамшуулах зорилгоор Пассив базальт панел хийц бүтээгдэхүүний худалдан авалтын 10 хувийн ваучер бэлэглэж байгаа. Та бүхэн амины орон сууц барих гэж байгаа бол эрчим хүчний хэмнэлттэй, смарт барилгын материалаа хөнгөлөлттэй үнээр авах боломжтой.

Дархан хот нь Монголдоо хамгийн анхны ногоон хот болох зорилт тавьсан Улаанбаатар хотын дараа орох 150 мянган хүн амтай хот байгаа. Дархан-Уул аймгийн засаг даргын саналаар бид шинэ бүтээгдэхүүний танилцуулгыг хийсэн ба үр дүнд нь төрийн албан хаагч болон залуу гэр бүлүүдийг дэмжих ногоон амины орон сууцны төсөл хамтран хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулсан. Барилгын зураг төсөл дуусангуут гэрээг баталгаажуулж, энэ намраас барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа. Үүнээс цааш бид ногоон барилга, орон сууцтай болох аймаг, орон нутагтай хамтран ажиллах төслүүдийг эхлүүлэх боломжтой болж зураг төсөл, холбогдох материалууд дээр ажиллаж эхэлсэн байна.

Ховд аймгийн төвд Ховдын ИТХ-тай хамтран 20 ширхэг амины орон сууц барих төсөл дээр хамтран ажиллахаар болсон, мөн л төслүүд эхлэхэд бэлэн болж байна. 2025 онд хэрэгжүүлэх нилээд том төсөл бол Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн захиргаатай хамтран 200,000 айл өрхийн дахин дулаалга хийх ажлыг эхлүүлэхээр санамж бичиг байгуулсан. Дахин дулаалгыг бид 2015 оноос хойш МУ-д анх эхлүүлж ЧХД, ЧД-т байрлах айлуудын дулаалгын гүйцэтгэсээр байгаа юм. Энэ туршлага, дата, зардал өртөгт үндэслэн нийслэлтэй хамтран эхний ээлжинд 10,000 айлын дулаалгыг 2025 ондоо хийх зорилго тавьсан, үүнээс 3000 айлын дахин дулаалгын санхүүжилт шийдвэрлэгдсэн ажлыг эхлүүлэх бэлтгэл хийж байна. Энэ дахин дулаалгын санхүүжилтийг Улс болон нийслэлээс ногоон эх үүсвэр болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын санхүүжилтээс хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа юм. Мөн айл өрхүүдийг өөрсдөө санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс томоохон 5 арилжааны банкуудтай гэрээ байгуулан ажиллаж байгаа ба дахин дулаалга болон данел хийцийг ногоон зээлээр худалдан авах боломжтой.

Засгийн Газраас Бүсчилсэн хөгжлийн хүрээлэн гэж байгуулж, томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зарласан ба манай компани 2025 онд Ховд аймгийг сонгож, үйлдвэр технологийн паркттай хамтран пассив базальт панел хийцийн бүтээгдэхүүний салбар үйлдвэр барих, мөн баруун бүсийн аймгуудыг хангах чулуун хөвөнгийн нөөц хадгалах агуулах барихаар санал тавьсан, энэ ондоо багтаан бүрэн хэрэгжүүлэх болно. Ховд аймаг нь эргэн тойрны 6 аймагтай шулуун замаар холбогдсон, 2 боомттой хил залгаа байрлалтай учир стратегийн ач холбогдолтой гэж үзэн Ховд аймгийг сонгосон.

Хувьцаа эзэмшигчид маань компанийн цаашдын бодлого, 2025 оны бизнес төлөвлөгөөг мэдэж байгаасай гэсэн үндсэн дээр чухал ач холбогдол өгч байгаа гол төслүүдийг танилцууллаа. Та бүхэн илүү дэлгэрэнгүй мэдээллийг компанийн вебсайт, пэйж хуудаснаас байнга авч байгаарай.

Маш тэвчээртэй сонсож хүлээн авсан та бүхэндээ маш их баярлалаа.

Хурлын хөтөлбөрийн дагуу цайны завсарлага болсон байна. Цайны завсарлагын өмнө бид өнөөдрийн хуралдаа биечлэн ирж оролцож байгаа хувьцаа эзэмшигч нараа урамшуулах зорилгоо манай хэрэгжүүлж буй СтартАп төсөл болох хөрсгүй тариалалтын Грөвүүл төхөөрөмжөөс 3 хүнд өгөхөөр бэлтгэсэн байгаа. Та бүхнийг бүртгэх явцад өгсөн ваучер дээрхи дугаарлалтыг сугалааны хайрцагт хийсэн байгаагаас сугалж 3 хүнээ сонгож өгье. Хэдийгээр бүгдэд нь өгмөөр байгаа ч шинэ СтартАп төсөл учраас өнөөдрийн хувьд боломжгүй байгааг ойлгоно биз ээ.

За ингээд хуралдаа ирж, сугалааны хайрцагт өөрийн ваучерны дугаарыг хуйлж хийсэн хүмүүсээсээ 3 хүнийг сонгож, урамшууллаа өгье. Хуралдаа ирж оролцсонд маш их баярлалаа. Та бүхэндээ эрүүл энхийг хүсье.



Хурлын дарга П.Нямдорж: Компанийн хараат бус хөндлөнгийн аудитын компанийг “Нексия Глобал монголиа аудит” ХХК-ийг ТУЗ-өөс сонгож, гэрээ байгуулан компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудит хийж дүгнэлт гаргасан. “Нексия Интернэшнл” гэдэг дэлхийд ТОП-8 ордог аудит, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч компанийн Монгол Улс дахь албан ёсны хараат бус гишүүн байгууллагаар ажилладаг ба манай компанийн хараат бус хөндлөнгийн аудитын дүгнэлт нь Англи, Монгол хэл дээр СТОУС-ын дагуу хийгдэж гарсан, энэ нь компанийн цаашдын хэрэгжүүлэх олон улсын төсөл, санхүүжилтэд чухал ач холбогдолтой юм. Мөн өнөөдрийн ХЭХ дээр хөндлөнгийн аудитын компанийн төлөөлөгчөөр аудитор Бат-Оргил хүрэлцэн ирсэн ба та бүхэн сонирхсон асуултаа асууж болохоор байгаа шүү. Та бүхэн компанийхаа үйл ажиллагаатай байнга танилцаж, нээлттэй мэдээлэл байнга авч байгаа гэдэгт найдаж байна.

За ингээд танилцуулах хэсэг маань дууссан тул та бүхнийг цайны завсарлага-д урьж байна.

Хурлын дарга П.Нямдорж: За одоо хөтөлбөрийн дагуу асуулт хариулт байна. Та бүхэн асуулт байгаа бол гарза өргөөд микрофон авсаарай. Асуулт байхгүй бол цааш үргэлжлүүлье.

Хурлын дарга П.Нямдорж: 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Ш.Энхтөрийг индэрт урьж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Энхтөр: Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг эрье. Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 оны 02 сарын 26-ны өдөр хуралдаад тус компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байгаа. Хурлын материалд дүгнэлт бүрэн эхээр авагдсан байгаа, уншиж танилцуулъя.

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

“Монгол базальт” ХК нь урт хугацааны судалгаа шинжилгээ, инноваци хөгжүүлэлт, тогтвортой өсөлтийг харуулж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаагаараа салбартаа тэргүүлэгч хэвээр байна. Энэ нь зөвхөн санхүүгийн үзүүлэлтээр хэмжигдэхгүй бөгөөд бидний нийгэм, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллөөр батлагдаж байгаа юм.

Бид хариуцлагатай үйлдвэрлэгч байж, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулагч байхыг зорьж, бүхий л үйл ажиллагаандаа чанарыг эрхэмлэн ажиллаж ирсэн бөгөөд 2024 онд бодитоор баталгаажуулж Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO9001:2015, ISO 14001:2015, ISO45001:2018 стандартуудын шаардлага хангасан хамт олон болж чадсан.

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хууль, компанийн дүрмийг удирдлага болгон 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийн, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Манай үйлдвэр 2024 онд нийт 146,000 хүн/цаг ажиллаж 2892.5 тонн чулуун хөвөн, 8456 метр шугам хоолойн дулаалга, 1084.2 метр оёмол хөнжил бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба 12.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 8.9 тэрбум төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй, 3.2 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан болно.

Бид зөвхөн үйлдвэрлэгч бус технологи хөгжүүлэгч байхад анхаарч ирсэн бөгөөд Нийслэл хотын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүлэмжийн хий, агаарын бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлж чадахуйц томоохон зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаагаас дурьдвал:

- НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ” болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд үүрэг, амлалт хүлээн нэгдэн орохоор зэхэж, бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг хангах “Тогтвортой хөгжлийн схем”-ийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Компанийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь Тогтвортой хөгжлийн 17 зорилтуудын 12 хэрэгжилтэд хувь нэмрээ оруулж байна.
- Парисын хэлэлцээрийн зорилтуудын дагуу хамтын ажиллагааг бий болгох, уур амьсгалын үйл ажиллагааг өргөжүүлэх, барилга байгууламж, барилгын салбарын уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилгот бүхий GlobalABC олон улсын эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын холбооны Монгол улсын анхны гишүүнээр элссэн. GlobalABC нийгэмлэгтэй хүчээ нэгтгэснээр бид салбарын байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадавхийг ашиглаж, утаагүй, үр ашигтай, уян хатан барилгыг хүн бүрт хүргэх зорилгын хэрэгжилтийг хурдасгах боломжтой болно.

- Байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, дугуй /recycle/ эдийн засгийн зарчимд нийцүүлэх зорилготой чулуун хөвөнгийн хаягдлыг дахин боловсруулах "BASALTCYCLE" хөтөлбөрийг эхлүүлсэн.
- Стратеги зорилгодоо хүрч, тогтвортой өсөлтийг бий болгох үнэт зүйлсийн нэг бол хүний нөөц, түүний тогтвортой байдлыг хангах хөтөлбөр бөгөөд компани ажилтнуудын сургалт хөгжүүлэлт, мэргэшүүлэн бэлтгэх, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. Мөн ирээдүйн залгамж халаа болсон оюутан залуус, багш судлаач, инженерүүдийн мэдлэг, ур чадвар, инженерчлэлийн оновчтой шийдлийг дэмжих, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх, бизнесийн байгууллага - их, дээд сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий "МОНГОЛ ИНЖЕНЕР-2024" нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд CAD/CAE/CAM улсын олимпиадыг амжилттай зохион байгуулсан болно.
- Нийслэл, хотуудын агаарын бохирдол, эрчим хүчний хэрэглээг багасгаж, иргэдийн орлогод суурилсан орон сууцыг бий болгох зорилгоор пассив хаусны угсармал бэлдэцийн үйлдвэрийг 2024 оны дөрөвдүгээр улиралд ашиглалтад орууллаа. Энэ үйлдвэр нь Пассив байшин барих 30см чулуун хөвөн дулаан тусгаарлагчтай, хана, дээвэр шалны хавтанг үйлдвэрлэх бөгөөд зураг төслийн дагуу шууд угсрах боломжтой хурдан хугацаанд дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлтэй амины орон сууцтай болох боломж юм.

Компанийн борлуулалтын орлого өнгөрсөн оноос 22.4 хувиар өссөн байгаа ч цэвэр ашиг багассан нь 2024 онд стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах олон талт зардлуудыг гаргаснаас гадна эдийн засгийн тогтворгүй байдал, инфляци, эрчим хүчний үнэ ханшны огцом өсөлт зэргээс шалтгаалсан гэж ТУЗ үзэж байна. Тухайлбал: Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үндсэн үйлдвэрийн өртөг зардлыг бууруулах өргөтгөл шинэчлэл хийх болон инноваци шингэсэн пассив байшингийн бүтээц хийцийн үйлдвэр, цементтэй шүршдэг базальтын үйлдвэрийн бүтээн байгуулалтуудад нийт 7.1 тэрбум төгрөг, өрсөлдөхүйц чадварлаг инженер техникийн ажилтнууд татах, сургаж хөгжүүлэх болон цалингийн зардалд нийт 2.5 тэрбум төгрөг, зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлтөд 8.4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Манай улсын төр засгийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын зах зээлийн хамгаалалтын бодлого хангалтгүй, тогтворгүй байгаагаас шалтгаалан бид гадны улсын чанар, стандартын шаардлага хангаагүй хямд үнэ бүхий шаарган хөвөн, шилэн хөвөн бүтээгдэхүүнтэй өрсөлдөж өнөөдрийг хүрсэн ба цаашид үүсч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тэсвэрлэх, даван туулахтай холбогдуулан байнгын хөгжүүлэлт хийж бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж байгаа гэдгийг дурьдах нь зүйтэй.

Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа нь засаглалын шинэчлэлтийг бий болгож, үр дүнд нь Компанийн засаглалын кодексын зарчмуудад нийцэж ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны "Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний зэрэглэл"-д 93 хувь буюу 109 хувьцаат компаниас наймдугаарт эрэмблэгдсэн болно.

"Монгол Базальт" ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь компанийн дунд хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангаж, цаг үеийн нөхцөл байдалд тохируулан санхүү болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийж "хангалттай сайн" ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

Хурлын дарга П.Нямдорж: За өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудал болох Монгол базальт ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах эсэх томъёоллоор санал хураая.

Санал хураах хугацаа 15 минут байгаа, та бүхэн бүртгэл баталгаажуулахад мсж-ээр ирсэн нууц үгээр нэвтэрч орж цахимаар саналаа өгөөрэй. Манай ажилтнуудаас заавар, тусламж авч болно.

Санал хураах хугацаа дуусч хурлыг үргэлжлүүлэв.

Хурлын дарга П.Нямдорж: Та бүхэн саналаа бүрэн өгч дууссан байх. Санал хураах хугацаа дууссан тул саналыг тоолж, тогтоолыг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг таныг урьж байна.

Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя.

2025 оны 04 сарын 30-ны өдөр Дугаар №2, Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2025 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын актыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх: нийт 41 хувьцаа эзэмшигч санал өгснөөс зөвшөөрсөн- 39, түдгэлзсэн- 0, татгалзсан- 2 буюу санал хураалтын дүнгээр санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 95.1 хувь нь зөвшөөрсөн байх тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг

Шийдвэрлэсэн нь:

Хурлын дарга П.Нямдорж: За тооллогын комиссын тогтоолоор санал хураалт хүчинтэйд тооцсон тул өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг танилцуулж байна.

Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол 2025 оны 04 сарын 30-ны өдөр, Дугаар 1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, 2025 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга П.Нямдорж гэжээ.

Хурлын дарга П.Нямдорж: За өнөөдөр цаг заваа зарцуулж, компанийнхаа хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцсон та бүхэндээ маш их баярлалаа. Хурал дууссан болохыг мэдэгдэж байна.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Танилцсан: Хурлын дарга

[Handwritten signature]

О.Билгүүн

П.Нямдорж

